



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 19/46

Улаанбаатар хот

Журам, норматив батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Бэлэг дурсгалын зүйл бэлтгэх, өгөх, тайлагнах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын норматив”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Бэлэг дурсгалын зүйл бэлтгэх, өгөх, тайлагнах журам”, “Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын норматив”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын захирал С.Золжаргалд даалгасугай.

3. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан журам, нормативыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг яамны төсөвт жил бүр тусгаж байхыг Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяад даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гадаад харилцааны сайдын 2000 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 15 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дипломат болон Консулын төлөөлөгчийн газруудад баримтлах хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын норматив”, 2 дугаар хавсралтаар баталсан “Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тушаалыг 2020 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.


САЙД



Н.ЭНХТАЙВАН

080176

Гадаад харилцааны сайдын
2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
А/46 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



БЭЛЭГ, ДУРСГАЛЫН ЗҮЙЛ БЭЛТГЭХ, ӨГӨХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Монгол Улсын Гадаад харилцааны сайд, дэд сайд, Гадаад харилцааны яам (цаашид “Яам” гэх)-ны Төрийн нарийн бичгийн дарга (цаашид хамтад нь “Яамны удирдлага” гэх) болон газрын захирал, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат болон консулын төлөөлөгчийн газрын тэргүүн (цаашид “ДТГ-ын тэргүүн” гэх) нараас Монгол Улсад айлчлал хийж буй болон албан ажлаар ирсэн гадаад улсын төр, засгийн адилтгах түвшний болон бусад албан тушаалтан (цаашид “гадаадын зочин, төлөөлөгч” гэх)-д өгөх бэлэг, дурсгалын зүйлийг бэлтгэх, өгөх, тайлагнах үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Бэлэг, дурсгалын зүйлийг ёсчлон бэлтгэх

1. Гадаадын зочин, төлөөлөгчид өгөх бэлэг, дурсгалын зүйл нь хүндэтгэл, талархал илэрхийлэх, баяр хүргэх гэсэн утгыг агуулах бөгөөд монгол үндэсний түүх, зан заншил, соёлын онцлогийг харуулсан бэлгэдлийн чанартай зүйл байна. Мөн яамны үйл ажиллагааг сурталчлан таниулсан хэвлэмэл материал, эд зүйл байж болно.

2. Гадаадын зочин, төлөөлөгчид өгөх бэлэг, дурсгалын зүйлийг сонгож бэлтгэхдээ үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтална.

3. Монгол Улсын түүх, зан заншил, соёлтой холбоотой тухайлан бэлтгэсэн бэлэг, дурсгалын зүйлийн онцлог, холбогдох тайлбарыг тухайн зочинд тохирох гадаад хэлээр бэлтгэж, хавсаргана.

4. Гадаадын зочин, төлөөлөгчид өгөх бэлэг, дурсгалын зүйлийг бэлтгэхдээ тухайн үндэстний зан заншил, шашин, онцлон дээдэлдэг болон цээрлэдэг зүйлс, тухайн зочин, төлөөлөгчийн сонирхдог зүйлс зэргийг харгалзан үзнэ.

5. Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон түүх, соёлын өвийн дурсгалын үнэт эдлэл, байгалийн үнэт эрдэнэс баялгийн болон бусад зүйлийг гадаадын зочин, төлөөлөгчдөд бэлэглэж, дурсгаж болохгүй.

6. Гадаадын зочин, төлөөлөгчдөд яамны удирдлагаас болон яамны газрын захирлуудаас өгөх бэлэг, дурсгалын зүйлийг баталсан төсвийн дагуу худалдан авах, ёсчлон бэлтгэх ажлыг яамны Дипломат ёслолын газар хариуцан зохион байгуулж, бэлэг, дурсгалын санг бүрдүүлнэ. Ингэхдээ яамны удирдлага болон тухайн газрын захиралтай зөвшилцөнө.

Гурав. Бэлэг, дурсгалын зүйл худалдан авах үнийн дээд хязгаар

1. Яамны удирдлагаас хүндэтгэл, талархал илэрхийлэх, баяр хүргэх гадаадын зочин, төлөөлөгчийг айлчлалын түвшин, эрхэлж буй албан тушаал, олон улс болон тухайн улс, байгууллагад хашиж буй албан тушаал, эзлэх байр суурь, нэр хүндээс нь шалтгаалан дараахь зэрэглэлд ангилна:

А/ нэгдүгээр зэрэглэлийн зочин, төлөөлөгчид Гадаад харилцааны сайдын урилгаар Монгол Улсад хоёр талын харилцааны асуудлаар яриа хэлэлцээ хийх, баримт бичигт гарын үсэг зурах зорилгоор албан ёсны айлчлал хийж байгаа гадаад улсын адилтгах түвшний албан тушаалтан, эсхүл түүнийг орлож, хавсарч байгаа албан тушаалтныг хамааруулна.

Б/ хоёрдугаар зэрэглэлийн зочин, төлөөлөгчид яамны удирдлагын урилгаар Монгол Улсад хоёр орны харилцаа, бүс нутгийн хийгээд олон улсын харилцааны асуудлаар яриа хэлэлцээ хийх, баримт бичигт гарын үсэг зурах, хурал зөвлөлгөөн, урлаг, соёл, спортын арга хэмжээ, түүхт ой, тэмдэглэлт үйл явдалд оролцох, эмгэнэл илэрхийлэх болон дамжин өнгөрөх зорилгоор ажлын айлчлал хийж байгаа гадаад улсын адилтгах түвшний албан тушаалтан, эсхүл түүнийг орлож, хавсарч байгаа албан тушаалтныг хамааруулна.

В/ гуравдугаар зэрэглэлийн зочин, төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлал хийж байгаа гадаадын зочин, төлөөлөгчийн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд багтсан гишүүдийг хамааруулна.

2. Зочин, төлөөлөгчийн зэрэглэл тус бүрийн онцлогт тохирсон бэлэг, дурсгалын зүйлийг сонгож бэлтгэхдээ үнийн дээд хязгаарыг дараах байдлаар тогтооно:

№	Албан тушаалтан	I зэрэглэлийн зочин, төлөөлөгчид өгөх бэлэг дурсгал /төгрөгөөр/	II зэрэглэлийн зочин, төлөөлөгчид өгөх бэлэг дурсгал /төгрөгөөр/	III зэрэглэлийн зочин, төлөөлөгчид өгөх бэлэг дурсгал /төгрөгөөр/
1.	Гадаад харилцааны сайд	1,000,000	250,001 - 500,000	100,000
2.	Гадаад харилцааны дэд сайд	900,000	150,001 - 400,000	100,000
3.	Төрийн нарийн бичгийн дарга	800,000	100,001 - 300,000	100,000
4.	Газрын захирал	-	100,000	100,000

3. Айлчлал, арга хэмжээний онцлог, хүрэх үр дүн зэргийг харгалзан нэгдүгээр зэрэглэлийн зочин, төлөөлөгчид өгөх бэлэг дурсгалын үнийн дээд хязгаараас давсан үнэ бүхий бэлэг дурсгалын зүйлийг батлагдсан төсөвт багтаан тухай бүр шийдвэрлэж болно.

4. ДТГ-ын тэргүүн нь суугаа болон хавсран суугаа орондоо дипломат ёслол, нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэх зэрэг ёслол хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулахдаа нэг хүнд **100,0** мянган төгрөгөөс илүүгүй үнэтэй бэлэг, дурсгалын зүйл өгнө.

5. Яамны удирдлагаас Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй гадаадын зочин, төлөөлөгч, эсхүл түүний гэр бүлийн гишүүнд **100,0** мянган төгрөгөөс илүүгүй үнэтэй амьд цэцгийн баглаа өгч болно.

6. Харилцааны зайлшгүй нөхцөл байдлыг харгалзан энэхүү журмын 3.2-т зааснаас бусад яамны албан тушаалтан бэлэг, дурсгалын зүйл өгч болох бөгөөд бэлэг, дурсгалын зүйл өгөх зардлын төсвийг яамны Төрийн нарийн бичгийн дарга батлана.

Дөрөв. Бэлэг, дурсгалын зүйл өгөх, солилцох

1. Монгол Улсад айлчилж байгаа болон албан ажлаар ирсэн гадаадын зочин, төлөөлөгчийн зөвхөн албан ёсны бүрэлдэхүүнд орсон хүмүүст тэднийг хүлээн авагч албан тушаалтан бэлэг, дурсгалын зүйл өгнө.

2. Нэг айлчлал, арга хэмжээний үеэр нэг хүнд нэгээс илүүгүй бэлэг, дурсгалын зүйл өгөх зарчим баримтална.

3. Гадаад харилцааны сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга дипломат шугамаар урьдчилан зөвшилцсөний дагуу гадаадын адилтгах зиндааны албан тушаалтантай бэлэг, дурсгалын зүйлийг биечлэн харилцан солилцож болно. Бусад бэлэг, дурсгалын зүйлийг дипломат шугамаар солилцоно.

Тав. Бэлэг, дурсгалын зүйлийг бүртгэх, тайлагнах

1. Яамны Дипломат ёслолын газар нь энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан бэлэг, дурсгалын зүйлсийн бүртгэлийг хөтлөхийн зэрэгцээ бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээ, тайлан гаргах, айлчлал, албан ёсны арга хэмжээний бэлтгэл хангах хүрээнд бэлэг, дурсгалын санд буй нөөцийн талаар лавлагаа, мэдээлэл өгөх үйл ажиллагааг хариуцна.

2. Бэлэг, дурсгалын зүйлсийн бүртгэлийг Дипломат ёслолын газрын бичиг хэрэг, архивын асуудал эрхэлсэн ажилтан, хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ-ын ёслолын асуудал эрхэлсэн ажилтан тус тус хөтөлнө.

3. Бэлэг, дурсгалын зүйлсийн бүртгэлд тухайн бүтээгдэхүүн, эд зүйлсийн бүртгэлд хамруулсан огноо, албан ёсны нэршил, фото зураг, бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн мэдээлэл, худалдан авсан үнэ, соёл урлагийн бүтээл бол бүтээлийн тайлбар, гардуулан өгсөн зочин, төлөөлөгчийн нэр албан тушаал, бэлэг дурсгалын зүйл дээр байршуулсан бичээс, айлын талд хэрхэн хүлээлгэн өгсөн зэрэг мэдээллийг оруулна.

Зургаа. Хариуцлага

Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--o000o--

Гадаад харилцааны сайдын
2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
АЧБ дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ХҮНДЭТГЭЛИЙН ЗООГ БАРИХ, ХҮЛЭЭН АВАЛТ ХИЙХ ЗАРДЛЫН НОРМАТИВ

1. Монгол Улсын Гадаад харилцааны сайд, дэд сайд, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга болон газрын захирал, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат болон консулын төлөөлөгчийн газрын тэргүүн хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийхэд уг ёслолын арга хэмжээнд зориулан баталсан төсөвт багтаана.

2. Монгол Улсын Гадаад харилцааны сайд, дэд сайд, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга болон газрын захирал, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат болон консулын төлөөлөгчийн газрын тэргүүн нараас Монгол Улсад айлчлал хийж буй болон албан ажлаар ирсэн гадаад улсын төр, засгийн адилтгах түвшний болон бусад албан тушаалтанд албаны ёсны зоог барихад нэг хүнд ногдох зардал нь 10 хүртэл хүн оролцох зоогт **250,0** мянган төгрөг, 50 хүртэл хүн оролцох зоогт **100,0** мянган төгрөг, 50-иас дээш хүн оролцох зоогт **80,0** төгрөгөөс тус тус илүүгүй байна. Хүлээн авалт хийх зардлыг зоогт зориулан тогтоосон хэмжээний 80 хувиар бодож тооцно.

--o000o--